

2023 оны гуравдугаар сар

- Нэр : Энхболд Маралгуа
- Улс : Монгол
- Шалгалт өгсөн газар : Монгол
- Шалгалт өгсөн сэдэв : Математик, нийгмийн ухаан,  
Япон хэл
- Илсэх хүсэлтээ илгээсэн сургуулийн тоо : 2
  - ※Сургууль тус бүрийн веб хуудаснаас  
мэдээлэл цуглуулсан
- Төгссөн сургууль : Шинэ Монгол
- Тэтгэлэг авдаг эсэх : Авдаг
  - ※Jasso гадаад оюутанд зориулсан тэтгэлэг,  
Ясудасангийн тэтгэлэг

## **Мөрөөдлөө биелүүлэхээр**

### **① Япон улсыг зорих болсон шалтгаан**

Миний хувьд анх 19-р зуунаас 20-р зууны Японы эдийн засгийн түүхийг судалсанаас хойш, Японы талаар улам ихийг мэдэх хүсэл эрмэлзэл төрж байсан юм. Дэлхийн 2-р дайны дараа Япон улсын эдийн засаг маш хурдацтай өссөний сацуу бараа бүтээгдэхүүний чанар нь ч дагаж сайжирсан нь, тухайн үеийн эдийн засгийн бодлого дээр нэмээд, Япон улсын өөрийн соёл ч мөн хүчтэй нөлөөлсөн хэмээн бодож, энэ талаар судлахаар Японы их дээд сургуулийг зорих болсон.

### **② Суралцаж буй хот, сургууль зэрэгээ сонгох болсон шалгаан болон хэрхэн бэлдсэн талаар**

Одоо би Кэйогийн их сургуулийн эдийн засгийн ангид суралцаж байгаа. Их сургуулиа мэрэгжлийн хүрээнд өндөр мэдлэг олгох эсэх мөн өөр улсад богино хугацаагаар солилцооны оюутанаар сурах боломж байгаа эсэхд анхааран сонгосон. Японы их сургуульд элсэн орох шалгалтадаа ахлах сургуулийнхаа 2-р

ангиас бэлдэж эхлэн, 3-р ангидаа жишиг болон жинхэнэ шалгалт зэргээ өгч туршлага хураасан. Мөн гадаад сурагчидын Японы их сургуульд элсэн орох шалгалт нь Япон сурагчидын их сургуульд элсэн орох шалгалтын агуулгатай давхцсан хэсэг их байсан тул ютүб субаг болон олон төрлийн сайтаас шалгалтад бэлдэх мэдээлэл цуглуулдаг байсан.

### ③ Шалгалтандаа бэлдсэн миний арга барил

Шалгалтандаа бэлдэхдээ ашигласан материалаас дурдвал, математикаа 『Чарт 1+A』 (『チャート式基礎からの数学1+A』) гэдэг Япон ном ашиглан бэлдэж байсан. Японы их сургуульд элсэн орох шалгалтын математикийн хэсэг нь Монголын хөтөлбөрт багтсан байдаг учир, хичээлээ сайн ойлгож давтахын хажуугаар энэхүү номноос мөн бодлого боддог байсан. Мөн олон төрлийн ном ашиглан, янз янзын бодлого өнгөцхөн бодохоос илүүтэйгээр, нэг номоо дахин дахин эргүүлэн бодож, бүх бодлогоо маш сайн ойлгосон нь шалгалтандаа өндөр оноо авахад минь тус болсон гэж бодож байна.

Харин нийгмийн ухааны шалгалтандаа 『Со го』 (『日本留学試験対策問題集 ハイレベル 総合科目』) -ийн ном ашиглан бэлдэж байсан. Нийгмийн шалгалтын агуулгань Монголын хөтөлбөртэй бараг л бүхлээрээ өөр учир эртнээс бэлдэх хэрэгтэй хичээлийн нэг байсан гэж бодож байна. Мөн дээрхтэй адил, нэг номоо дахин дахин эргүүлэн уншиж, ойлгож цээжлэх нь чухал байсан.

### ④ Их сургуулийн хичээл болон оюутны амьдрал

Анх Японд ирэхэд бүх зүйлс шинэ, сурж мэдэхийн хүсэлээр дүүрэн байсаны зэрэгцээ өөрийн амьдралын гараагаа эхлүүлнэ гэдэгээс бага зэрэг айж байсанаа одоо ч тод санаж байна. Их сургуулийн хичээл эхлээд 1 сар өнгөрөхөд шинэ амьдралдаа нилээд дасчихсан, хичээлдээ шамдан суралцах боломж бүрдсэн байсан. Японы их сургуулиуд гадаадын оюутнаа их дэмжиж, Японд анх ирээд суурьших хүртэл нь олон талаар тусалдаг гэж боддог. Харин өөрөө даалгавараа

түгдрэлгүй хийж, Япон хүүхдүүдээс ч дудахгүй хичээлээ сайн ойлгож, шалгалтаа чамжилттай өгөхийн тулд Япон хэлний өндөр мэдлэг хэрэгтэй. Японы их дээд сургуульд элсэн орох шалгалт, Япон хэлний түвшин тогтоох шалгалт зэрэгт сайн авсан байсан ч яг биеэр их сургуулийн хичээлд оролцож, чанартай бичих зэрэгт илүү өндөр Япон хэлний мэдлэг хэрэгтэй болох учираас хэлээ сайн үзэх хэрэгтэй гэж бодож байна.

#### **⑤ Монголоосоо Японы их дээд сургууль руу хүсэлтээ явуулах системийг ашигласаны давуу**

Японд ирэлгүйгээр Монголдоо Японы их дээд сургуульд элсэн орох шалгалтаа өгч, хүсэлтээ элгээх систем нь олон талаар тус болсон. Жишээлбэл зардалын хувьд маш хэмнэлттэй байсан.

Сургуулийнхаа веб хуудаснаас хэрэгтэй материал болон шалгалтаа харж, элсэн орох хүсэлтээ шуудангаар явуулах л байсан тул маш амар байсан гэж бодож байна. Мөн давхар олон сургууль болон факултетэд өргөдлөө явуулах боломж илүү нээгдсэн гэж хэлж болно. Миний хувьд энэхүү системээр хүсэлтээ явуулсан тул Кэйо их сургуулиас гадна өөр нэгэн их сургууль, мөн Кэйо их сургууль дундаа эдийн засдаг болон бизинэсийн факултетэд өргөдлөө илгээж тэнцэж чадсан.

#### **⑥ Монголоосоо Японы их дээд сургууль руу хү**

Сонирхож буй их сургуулийнхаа сайтнаас өөрийн факултетын элсэх журамд Монголоосоо материалаа бүрдүүлж өрөгдлөө явуулах боломж байгаа эсэхийг эртхэн шалгахыг зөвлөж байна. Мөн Монголоосоо материалаа бүрдүүлж өрөгдлөө явуулах системийн өрөгдлийн хугацаа нь жирийн элсэлтийн хугацаанаас бага зэрэг эрт байдаг тул анхаарах хэрэгтэй. Энэхүү системээр элсэлт авдаг их сургуулиудын зарим нь материал дээр бүрэн үндэслэж тэнцэх эсэхийг нь шийддэг учир бүх материал, шалгалтын дүн нь маш чухал байдаг. Тиймээс аль болох эртнээс

бэлдэж эхлэх нь тустай гэж бодож байна.



Их сургуулийнхаа нээлтэндээр



Амралтын өдөрийн аялал